



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 0/427

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 15.3, 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Химийн хорт болон аюултай бодис ашиглан үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх “хяналтын хуудас”-ыг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ батлагдсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа Б.Баянмөнх)-т даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



ГАРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны 1 дугаар сарын 17-ны өдрийн  
13/А.2.1 дугаар тушаалын хавсралт



ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС  
АШИГЛАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ,  
БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:		
Шалгуулагч этгээдийн нэр:		
Регистрийн дугаар:		
Объектын нэр, хаяг, солбицол:		
Байгуулагдсан огноо:		
Үйл ажиллагааны чиглэл:		
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:		
Хяналт шалгалт хийсэн огноо:	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн огноо:	Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо:
Шаардлага хангасан асуултын тоо:	/...../...../	/...../...../
Шаардлага хангаагүй нийт оноо:	/...../...../	/...../...../
Хууль сахин мөрдөлтийн хувь:	/...../...../	/...../...../
Эрсдэл үүсэх магадлалын хувь:	/...../...../	/...../...../
Эрсдэл үүсэх магадлал:	/ их, дунд, бага /	/ их, дунд, бага /

2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
<b>I. Баримт бичгийн бүрдүүлэлт</b>				<b>16</b>		
1	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.14 дэх заалт	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй эсэх ?		4		
2	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт	Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт зарцуулалтын тайланг холбогдох байгууллагад хүргүүлдэг эсэх ?		4		
3	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 5.1.5 дахь заалт	"Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодис"-ын жагсаалтад орсон бодис ашигладаг бол Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн дүгнэлттэй эсэх ?		4		
4	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай	Болзошгүй осол аваарын үед ажиллах ослын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан эсэх ?		4		

	бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 2.1.5 дахь заалт					
<b>II. Боловсон хүчний хангамж, мэргэшүүлэлд</b>			<b>8</b>			
5	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 5.2.10 дахь заалт	Химийн хорт болон аюултай бодисын асуудал хариуцсан мэргэжлийн ажилтантай эсэх ?	4			
6	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 2.1.6, 2.1.8 дахь заалт	Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах, хамгаалах багаж хэрэгслийг ашиглах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад хамруулсан эсэх ?	4			
<b>III. Агуулахын зохион байгуулалт, тоног төхөөрөмж</b>			<b>44</b>			
7	"Химийн хорт ба аюултай бодисын тухай хуулийн 10 дугаар зүйл 10.3 дахь заалт	Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой эсэх ?	4			
	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын	Агуулахад нэг төрлийн химийн бодисыг давхарлаж хураахаар				

8	2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 3.5.8 дахь заалт	бол эвдэрч гэмтэх, нурах эрсдэл үүсгэхгүй, 3 метрээс ихгүй өндөртэй байна гэсэн шаардлагыг хангасан эсэх ?		4		
9	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 3.5.9 дэх заалт	Холимог хадгалалтаар хадгалах үед химийн бодисыг тус тусад нь ялгаж хадгалах ба хоорондын зай нь 2 метрээс багагүй эсэх ?		4		
10	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 3.5.10 дахь заалт	Химийн бодисын тавиур нь бат бөх материалаар хийгдсэн, даацын тэмдэглэгээг хийсэн, унахаас хамгаалсан, өргөх төхөөрөмж ашигладаг бол хамгаалсан саадыг эргэн тойронд байрлуулсан эсэх ?		4		
11	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай	Химийн бодисыг нарны хэт ягаан туяа тусахааргүй, хор аюулын лавлах мэдээлэлд заагдсан хадгалалтын горимын шаардлага хангасан		4		

	бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 3.5.1 дэх заалт	нөхцөлд хадгалсан эсэх ?				
12	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ын 3.5.4 дэх заалт	Хэд хэдэн төрлийн бодисыг нэг агуулахад хадгалахдаа тусгаарлагч дотоод ханаар заагласан, шатамхай биш бодисоор тусгаарласан, эсвэл галд тэсвэртэй материалаар хийсэн шүүгээ болон аюулгүй тасалгаанд хадгалдаг эсэх ?	4			
13	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	Агуулах нь хадгалж буй бодисын хор аюулын мэдээлэлд заасан шингээгч материал, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй эсэх ?	4			
14	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014	Аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд харагдахуйцаар байрлуулсан эсэх ?	4			
15	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014	Агуулахын дээвэр нь галд тэсвэртэй материалаар хийгдсэн, борооны ус тогтохооргүй, ус зайлуулах хоолойтой эсэх ?	4			
16	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	Агуулахын барилга нь аюулт үзэгдэл, ослын үед ашиглах аврах гарцтай уг хаалга нь гадна талдаа цоожгүй, дотор талаасаа түгжигддэг, ямар ч тохиолдолд дотроосоо онгойдог эсэх ?	4			
	Химийн хорт болон аюултай	50 тн-оос доош бодис хадгалдаг агуулах нь дотроо эмнэлгийн анхан шатны тусламж				

17	бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	үзүүлэх хайрцагтай байх ба 50 тн-оос дээш бодис хадгалдаг агуулах нь эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөөтэй эсэх ?	4			
<b>IV. Агуулахын гадна орчин</b>			<b>16</b>			
18	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	Хүн ам суурьшсан орон сууц, гэр хорооллын нутаг дэвсгэрт, усан сан бүхий хамгаалалтын бүсэд, үерийн аманд, усан хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн муж дотор байгаа эсэх ?	4			
19	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	Зэргэлдээх барилга байгууламжаас тэсрэмтгий бодис хадгалах агуулах нь 250м-ээс, шатамхай бодис хадгалах агуулах нь 30м-ээс багагүй зайд байрласан эсэх ?	4			
20	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014	Химийн бодисын агуулах нь 1.8м-ээс багагүй өндөртэй хамгаалалтын хашаатай, хашаа нь цоожтой, шөнийн цагаар гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй эсэх ?	4			
21	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	Үерийн хамгаалалтын далан, ой хээрийн түймрээс хамгаалах зурвастай эсэх.	4			
<b>V. Задгай агуулахад тавигдах шаардлага 16 /цаг агаарын нөлөөнд өртдөггүй бодис материал, шатамхай шингэн, бортоготой хийнүүдийг хор аюулын лавлах мэдээлэлд заагдсан нөхцөлийг харгалзан задгай агуулахад хадгалж болно/.</b>						
22	Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх,	Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүтэн байдал, тосгуур, суурины идэгдэлт, тавиурын холбоосны бүрэн бүтэн байдал, химийн бодисын сав баглаа боодолд дотоод хяналт тавьж ажилладаг эсэх ?	4			

	ашиглах, устгах журам"-ын 3.5.17 дахь заалт					
23	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014	Химийн бодис хадгалах зориулалтын болон галд тэсвэртэй материалаар хийгдсэн халалтаас хамгаалах давхарга бүхий хөдөлгөөнгүй суурилагдсан металл чингэлэгтэй эсэх ?		4		
24	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014	Задгай агуулах нь химийн бодис тархахаас хамгаалсан ус нэвчдэггүй материалаар хийгдсэн цуглуулах талбайтай эсэх ?		4		
25	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014	Цаг агаарын нөлөөлөл болон нарны гэрэл шууд тусахаас хамгаалсан хамгаалалт, дээвэртэй эсэх ?		4		
<b>Нийт оноо</b>				<b>100</b>		

### 3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг	Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг
/албан тушаал/	/албан тушаал/	/албан тушаал/
/овог, нэр/	/овог, нэр/	/овог, нэр/
/гарын үсэг, тэмдэг/	/гарын үсэг, тэмдэг/	/гарын үсэг, тэмдэг/

### ТАЙЛБАР:

.....

.....

.....

.....